

## АГУУЛГА

1. ТӨМӨРТЭЙН УУРХАЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	3
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	4
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ .....	5
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	6
5.1. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	6
5.2. ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХИ УСНЫ НӨӨЦӨНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	7
5.3. ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	8
5.4. ГАЗРЫН ХЭВЛИЙД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	9
5.5. УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	10
5.6. АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	11
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	12
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	12
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	13
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	13
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	14
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	16
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
15. ТӨМӨРТЭЙ УУРХАЙН 2023 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН НИЙТ ЗАРДАЛ.....	20

## 1. ТӨМӨРТЭЙН УУРХАЙН ТАНИЛЦУУЛГА

**Ерөнхий мэдээлэл:** “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-ийн Төмөртэйн төмрийн хүдрийн ил уурхай нь 2008 оны 2 сарын 28-ны өдрөөс эхлэн 30 жилийн хугацаатай 13319А тоот тусгай зөвшөөрөл бүхий лицензийг эзэмшиж эхэлсэн. Төмөртэйн уурхай нь 2011 оны 9 сарын 28-ны өдрөөс эхлэн Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба Монгол Улсын Компанийн тухай хууль, Иргэний хууль, Төрийн болон нутгийн өмчийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

**Ашиглалтын талбай:** 1200 га.

**Нөөц:** Ордын хэмжээнд эрлийн шатны ажлыг 1979-1980 онд, эрэл үнэлгээний ажлыг 1981 онд, урьдчилсан хайгуулыг 1921-1984 онд, нарийвчилсан хайгуулын ажлыг 1990-1992 онуудад тус тус хийж гүйцэтгэсэн. Төмөртэйн төмрийн хүдрийн орд нь 229.2 сая тн төмрийн хүдрийн нөөцтэй. Үүнээс Зүүн хэсгийн зүүн биетийн хүдрийн нөөц 122,1 сая тн бөгөөд исэлдсэн хүдэр 6950.6 мянган тн, бага хүдэртэй хүдэр 47158.9 мянган тн, хүхэрлэг хүдэр 68085.2 мянган тн байна.

**Байршил:** Төмөртэйн төмрийн хүдрийн орд нь Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт Улаанбаатар хотоос хойд зүгт 360 км, Дархан-Уул аймгийн төв Дархан хотоос 130 км, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төвөөс баруун урагш 20 км зайд байрлана.

**Зам харилцаа:** “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК нь 2015 онд Сэлэнгэ аймгийн Дулаанхан сумын 4 замын уулзвараас Төмөртэйн уурхай хүртэл 70 км засмал зам болон 12 км сайжруулсан шороон замыг тавьж, ашиглалтанд оруулан ашиглаж байна.

**Боловсон хүчин:** 276 ажилчид 4 ээлжээр ажилладаг.

**Цахилгаан хангамж:** Эрчим хүчний дэд станцтай, төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон.

**Усны хэрэгцээ:** Гүний худаг ашигладаг. Технологийн усалгаанд гадаргын ус хуримтлуулах сангаас авч ашигладаг.

**Дулаан хангамж:** Хоолны газар, кемп, оффис, ахуйн болон операторын өрөөнүүдэд цахилгаан халаагуур ашигладаг.

## **2. ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

**Төсөл хэрэгжих орчны байгалийн нөхцөл, уур амьсгал:** Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн уур амьсгалын ерөнхий төлөв байдал нь хоног, сар, жилийн агаарын температурын агууриг нх, хур тунадасны жилийн доторх хуваарилалт жигд бус, цаг уурын огцом өөрчлөлттэй гэх зэрэг эх газрын эрс тэс уур амьсгалаар тодорхойлогдох бөгөөд энд эх газарлаг байдлын Конрадын индексийн дундаж утга 7.0-7.5 байна. Төмөртэйн орд байрлах бүс нутаг нь цас ихтэй удаан үргэлжлэх өвөл, хүйтэн, хүчтэй салхи шуурга ихтэй хавар, харьцангуй халуун боловч үе үе сэрүүсдэг зун, өглөө оройн агаарын температурын агууриг ихтэй намрын улиралтай.

Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хангай-Хэнтийн уулархаг их муж, Орхон Сэлэнгийн бэсрэг уулсын мужид багтана. Хөрсөн бүрхэвчийн хувьд хөрс-газарзүйн мужлалаар Монголын хойд бэсрэг уулсын мужийн уулын ойн бараан, уулын нугат-ойн, уулын хар шороон хөрстэй Хэнтийн баруун тойрогт хамаарах ба ургамалжилтын хувьд өвөр байгалийн бүсэд хамрагдана. Тухайн орд байрлах нутаг дэвсгэр нь дэлхийн ус хагалбарын хойд мөсөн далайн ай савд, Монгол орны усны 29 сав газрын Хараа-Ерөө голын сав газарт хамаарагдах бөгөөд гол мөрөн, гадаргын усны сүлжээ харьцангуй сайтай.

**Нийгэм-эдийн засаг, дэд бүтцийн төлөв байдал:** Дархан хотоор дайрч өнгөрдөг авто болон төмөр замаар Улаанбаатар хоттой холбогдоно. Ордоос Дархан хот хүртэл 130 км зайтай. Улаанбаатар-Сүхбаатарын авто зам тус ордоос 80-85км зайд өнгөрнө. Төмөртэйн төмрийн хүдрийн орд бүтэн жилийн турш бусад хот сууринтай зам тээврээр холбогдох боломжтой. Дархан, Бугантын 110 кВ-ийн шугам бий. Бугантаас Хүдэр сум хүртэл татсан шугам нь Төмөртэйн ордоос 10км зайд өнгөрнө.

Уурхайн гадаад тээвэрт төмөр замыг ашиглах бөгөөд төмөр зам нь Ерөө-Баянгол төмөр замаар дамжин улсын төмөр замын үндсэн сүлжээтэй холбогдсноор Монгол улсаас экспортлогдох төмрийн хүдэр, боловсруулсан бүтээгдэхүүнийг ОХУ, БНХАУ болон олон улсын төмөр замын сүлжээгээр дамжин Япон, Өмнөд Солонгос, Казакстан, Ази номхондалайн орнууд болон Европийн зах зээлд гаргах боломжтой. Төмөртэйн төмөр зам нь иж бүрэн тоноглогдсон терминаль, гаалийн хяналтын бүс, төмөртэйн өртөө зэргээс бүрдэнэ. Усны хэрэгцээг газрын доорхи усаар хангадаг. Одоогийн байдлаар технологийн хэрэгцээнд ус ашиглахгүй бөгөөд хуурай соронзон баяжуулах үйлдвэрт хүдэр боловсруулж байна. Мөн уурхайн зам талбайн тоосжилт дарахад ил уурхайд орж ирэх шүүрлийн усыг ашиглана. Унд ахуйн зориулалтаар 2 гуний худаг гаргасан. Уурхайн кемпд одоо ашиглаж

буй 2.0 л/сек ундаргатай ба 1 худаг нь төслийн унд ахуйн хэрэглээг бүрэн хангах боломжтой.

### **3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

**Агаарын чанар:** Уурхайн үйл ажиллагааны үед хөрс хуулах, хүдэр болон хөрсийг ачих, буулгах, тэсэлгээ зэрэг уул уурхайн үйл ажиллагааны улмаас ихээхэн хэмжээний тоосжилт үүсч агаарын чанарт сөргөөр нөлөөлнө. Түүнчлэн ашиглалтанд өртөж эвдэрсэн талбай, тээвэрлэлтийн зам болон гадаад, дотоод овоолгоос үүсэх сул шороо тоосжилтын эх үүсвэрт хамаарна. Уурхайд өрөмдлөг, тэсэлгээ хийх, уул уурхайн хүнд машин механизмын хөдөлгүүрээс гарах утаа зэрэг нь азотын ислүүд, хүхрийн ислүүд, угаарийн хий болон бусад хортой хийнүүдийг агаар орчинд ялгаруулж агаарын бохирдол үүсгэнэ.

**Усан орчин:** Олборлолтын үйл ажиллагаатай холбоотойгоор уурхайд орж ирсэн усыг шүүрүүлэн зайлуулах шаардлага тулгарна. Үүнээс үүдэн гүний усны нөөцийн хомсдол бий болох сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай. Ийнхүү гүний усны түвшинг бууруулснаар хөрсний хуурайшилт, ургамлан нөмрөг устах зэрэг дам нөлөөллүүд үүсэх магадлалтай. Мөн бензин дизель бусад хортой бодис, шингэн, ахуйн хог хаягдал, шингэн хаягдлаас үүдэлтэйгээр гадаргын болон гүний усны бохирдол үүсч болзошгүй.

**Хөрс, газрын гадарга хэвлий:** Уурхайн ашиглалтаас хөрс, газрын гадарга, хэвлийд ихээхэн сөрөг нөлөө үзүүлнэ. Уурхайн малталт, гадаад овоолгын суурийн талбай, хөрсний овоолгын суурийн талбай, тээвэрлэлтийн зам, бусад дагалдах байгууламжийн орчин зэрэг газруудад хөрсөн бүрхэвч ашиглалтанд өртөж эвдрэлд орж үржил шимээ алдана. Үүнээс гадна бензин, дизел зэрэг нефтийн бүтээгдэхүүн, хатуу, шингэн хаягдлаар хөрс бохирдох магадлалтай. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөлд ордын чулуулаг хөрс эвдрэлд орж байгалийн тогтолцоо алдагдах, газрын гадарга эвдрэлд орж суулт үүсэхээс гадна гулсах, нурах, цөмрөх, ургамлан нөмрөгийг хуулснаар гадаргын чулуулаг өгөршиж эвдрэлд орон ил талбайгаас тоос шороо хийсэх, ухсан газар болон ан цавд гулсалт, нуралт, цөмрөлт үүсэн хүн, мал унаж бэртэх, газрын хэвлий дэх бусад дагалдах ашигт малтмалын нөөц хомсдох зэрэг хамаарна.

**Ургамлан нөмрөг:** Уурхай орчимд уурхайн карьер болон овоолгуудын талбайн орчим ургамлан нөмрөг хөрстэй хамт хуулагдан устана. Мөн ургамлан нөмрөг машин техникийн хөлд талхлагдах, уурхайн дагалдах байгууламжуудын орчимд хүний болон машин техникийн нөлөөгөөр хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгийн өөрчлөлт, доройтолт бий болох, замын тоос шороонд ургамлан нөмрөг дарагдаж ургамлын бодисын солилцоо

алдагдах, фотосинтезийн идэвхи буурах цаашлаад өсөлт удаашрах, ургахаа болих зэрэг сөрөг нөлөөлөл үүснэ. Үүнээс гадна хөрсний эвдрэлд орсон хэсгүүдэд хөл газрын ургамал ихээр ургаж энэ нь хүний эрүүл мэндэд таагүй нөлөө үзүүлнэ.

**Амьтны аймаг:** Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүн машин, техникийн төвлөрөл, хөдөлгөөн, дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн нөлөө зэргээс тухайн нутаг дэвсгэрийн амьтад дайжих, тархац нутаг хумигдах, тэдгээрийн идэш тэжээл хомсдох гэх мэт шууд нөлөөлөл үүснэ.

#### **4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Төмөртэйн уурхайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, БОНБНУ, байгаль орчны аудит, газрын төлөв байдал чанарын хянан баталгаа болон мэргэжлийн хяналтын байгууллага, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын заавар зөвлөмж, шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллахад оршино. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах,
- Компанийн байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх,
- Хог хаягдлын менежментийг бий болгох
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Талуудын оролцоог хангах, ОХШХ-г олон нийтийн оролцоог хамруулах, тайлагнах тогтолцоог сайжруулах зэрэг багтана.

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

## 5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Өрөмдлөг тэсэлгээ хийх, хөрс хүдэр болон хаягдал ачиж буулгах, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх	Уурхайн дотоод тээврийн зам, талбайг усны машин ашиглаж усалж, чийглэх	Уурхайн болон уурхайн тээврийн зам	тн	20-40	Дотоод зардал	Хуурайшилт ихтэй дулааны үед тогтмол хэрэгжүүлнэ	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Тээврийн хэрэгслийн хөдөлгүүр дэх түлшний дутуу шаталтаас агаарт хортой хий ялгарах.	Тээврийн хэрэгслийн сул ажиллагааг хязгаарлах, хяналт тавих	Уурхайн бүх машин, механизм тээврийн хэрэгсэл	-	-	Дотоод зардал	Тогтмол	Агаарын тухай хууль, MNS 4585:2016
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хөрсний эвдрэл нэмэгдэх, агаар дахь тоосны хэмжээ нэмэгдэх	Тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах тэмдэг тэмдэглэгээг сайжруулах, шинэ зам үүсгэхгүй байхад анхаарах	Уурхайн дотоод тээврийн зам	-	-	200,000	Жилд 2 удаа	MNS 4596:2007
Хог хаягдлаас үүдэлтэй таагүй үнэр, өвчин үүсгэгч агаар орчинд тархах	Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулж, ариутгал хийх	Хогийн цэгүүдийн орчин	-	-	Хог хаягдлын хэсэгт тусгасан	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
<b>Нийт</b>					<b>200,000</b>		

**5.2. Гадаргын ба газрын доорхи усны нөөцөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Уурхайн ус шүүрүүлэлт, усны хэрэглээнээс газар доорхи усны нөөцийн хомсдол үүсэх	Харьяалагдах сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх	Усан хангамжийн эх үүсвэр, шүүрлийн ус	-	-	Гэрээнд заасны дагуу төлбөр төлөх		Жил бүр	Усны тухай хууль
	Усыг зүй зохистой хэрэглэх дадлыг хэвшүүлэх		-	-			-	
	Усны чанар, нөөцийн мониторинг хийх		-	-	ОХШХ-т тусгасан		MNS 5775:2014	
Ус бохирдож, улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Усны эх үүсвэрийг хамгаалах, ойр орчныг цэвэрлэх, хог хаягдлаар бохирдуулахгүй байх	Унд ахуйн худаг	-	-	Дотоод зардал		Тогтмол	Усны тухай хууль, Ариун цэврийн тухай хууль
	Усан сан бүхий газруудад хамгаалалтын самбар байршуулах	Сум орон нутгаас заасан газарт	ш	3	300,000		Жилд 1 удаа	Усны тухай хууль
Усны чанар, найрлага өөрчлөгдөх, бохирдох	Усны шинжилгээг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заасан хугацаанд хийлгэх	Хяналтын цэгүүд	-	-	ОХШХ-т тусгасан		Жилд 2 удаа	MNS 900:2018 MNS 6148:2010 MNS 4943:2015
<b>Нийт</b>					<b>300,000</b>			

## 5.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Олборлолт, уурхайн дагалдах барилга байгууламж, уурхайн дотоод тээврийн зам агуулахуудын доор ашиглалтад өртсөн хөрс, газрын гадарга, хэвлий байгалийн төрх байдлаа бүр мөсөн алдах	Боломжит хэсгүүдэд ногоон байгууламж, тохижилтын ажил хийх, сайжруулах	Уурхайн захиргаа, бусад орчин	-	-	Дотоод төлөвлөлтөөр		Тогтмол	MNS 5918:2008
Шатах, тослох материал угаагдаж, зөөгдөн, хөрсөн бүрхэвч бохирдох	ШТМ-ын хадгалалтад хяналт тавих, ШТМ хадгалах цэгийг бетонжуулах	ШТМ хадгалах цэг	м <sup>2</sup>	-	1,000,000		Жилд 1 удаа	MNS 4628:1998
Хатуу, шингэн хог хаягдлаар хөрс бохирдох	Хог хаягдлыг төрөлжүүлэн савлаж ангилан ялгах, түр хадгалах цэгт хуримтлуулан зөвшөөрөгдсөн цэгт нийлүүлэх	Төсөл хэрэгжих талбайн хэмжээнд	-	-	Хог хаягдлын менежмент хэсэгт тусгасан		Тогтмол	Хог хаягдлын тухай хууль, MNS 5916:2008 MNS 5344:2011



Уурхайн үйл ажиллагааны улмаас хөрс эвдрэх, үржил шим алдагдах, бохирдох	Хөрсний дээж авч бүтэц шинж чанарыг ОХШХ-т заасан хугацаанд тодорхойлуулах	Хяналтын цэгүүд	удаа	1	ОХШХ-т тусгасан	Жилд 1 удаа	MNS 5850:2008
Хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх	Хөрс шорооны овоолгыг төлөвлөсөн талбайд эмх цэгцтэй хийх, тэмдэгжүүлэх	Шимт хөрсний овоолго	-	-			MNS 5916:2008
	Шимт хөрсний шимт чанараа алдсан эсэхт хяналт тавих		удаа	2	200,000	Жилд 2 удаа	MNS 3310-91
<b>Нийт</b>					<b>1,200,000</b>		

**5.4. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Газрын хэвлий ашигласан төлбөрийг хугацаанд нь төлөөгүйгээс болж уурхайн үйл ажиллагаа хаагдах	Газрын хэвлийг ашигласан төлбөрийг хугацаанд нь төлөх	Уурхайн нийт талбай	га	1200	Газар ашиглах гэрээний дагуу		-	Газрын хэвлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл
<b>Нийт</b>					<b>Газар ашиглах гэрээний дагуу</b>			

## 5.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хүн техникийн хөлөөр ургамлан бүрхэвч талхлагдах	Уурхайн үйл ажиллагаанаас ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллийг судлах	Уурхайн хэмжээнд	-	-	500,000		Жилийн турш	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Хүн техникийн хөлөөр ургамлан бүрхэвч талхлагдах	Боломжит хэсгүүдэд ногоон байгууламж, тоосжилтын ажил хийх	Уурхайн захиргаа, бусад орчин	-	-	Дотоод зардал		Тогтмол	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Төслийн үйл ажиллагааны үед үүссэн тоос шороо ургамал дээр унаж хуримтлагдсанаар ургамлын фотосинтез явагдах боломжгүй болж, ургамал ургах чадвараа алдах	Тоосжилт дарах усалгаа хийх	Тоосжилт үүсч буй эх үүсвэрүүд	-	-	Дотоод зардал		Хуурайшилт ихтэй үед тогтмол хэрэгжинэ	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
<b>Нийт</b>					<b>500,000</b>			

**5.6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Уурхайд хийх тэсэлгээ, тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс гарах дуу чимээнээс тухайн нутаг дэвсгэрийн амьтад дайжих	Уурхайн үйл ажиллагаанаас амьтдад үзүүлэх сөрөг нөлөөллийг судлах	Уурхайн хэмжээнд	-	-	600,000		Жилийн турш	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Идэш тэжээлийн хомсдол үүсч амьтад дайжих								
<b>Нийт</b>					<b>600,000</b>			

## 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Техникийн нөхөн сэргээлт хийх	-	-	-	-	-	-	-
Биологийн нөхөн сэргээлт хийснээр орчны байгалийн тэнцвэрийг ойртуулах, амьтан болон иргэдэд тааламжит байдлыг үүсгэх	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймагт мод тарих	ширхэг	1,500	3,000	4,500,000	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 4 дүгээр зүйл	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 4 дүгээр зүйл
<b>Нийт</b>					<b>4,500,000</b>		

## 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Техникийн нөхөн сэргээлт хийж агаар, хөрс, усанд үзүүлэх сөрөг нөөгөөсийг бууруулах, мал амьтан нүх нурангинд унаж гэмтэх эрсдэлээс сэргийлэх	Орон нутагтай зөвшилцсөний үр дүнд техникийн нөхөн сэргээлт хийх талбайг сонгоно	Дүйцүүлэн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэхээр сонгон авсан газар нутагт	5.4	2,300,000	12,420,000	Жилийн турш	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 4 дүгээр зүйл
<b>Нийт</b>					<b>12,420,000</b>		

**8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Байхгүй	Уурхайн үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрт суурьшиж буй иргэд байхгүй учир нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ явагддаггүй	-	-	-	-	-	-
<b>Нийт</b>					-		

**9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Улаанбаатар Их Сургуулийн археологийн судалгааны багийн хийсэн археологийн тандалт судалгааны явцад нийт төслийн талбайн хэмжээнд гадна талдаа ил мэдэгдэх ямар нэгэн түүхийн дурсгал илрээгүй байна	Гэвч уурхайн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвд хамаарах олдвор олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг зогсоож, мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэж хамтран ажиллана.	-	-	-	-	-	-
<b>Нийт</b>					-		

## 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Уурхайн хөрсний нуралт	Хөрсний эвдрэл гэмтлийн талаарх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэгийг байнга хийх	Уурхайн газар нутагт	-	Дотоод зардал		Байнга	Уурхайн дотоод журмын дагуу
Техникийн аваар	Техник тоног төхөөрөмжийн ашиглалтын болон аюулгүй ажиллагааны заавар дүрмийг чанд баримтлах	Уурхайн бүх нэгжид	-	Дотоод зардал		Байнга	ХАБЭА-н тухай хууль
Мэргэжлээс шалтгаалах өвчлөл	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх	Ажлын байр бүрд	-	Дотоод зардал		Байнга	ХАБЭА-н тухай хууль
Үер	Гамшгаас хамгаалах эрсдэлийн үнэлгээний дагуу	Уурхайн газар нутагт	-	Дотоод зардал		Байнга	Гамшгаас хамгаалах тухай хууль
Газар хөдлөлт	Гамшгаас хамгаалах эрсдэлийн үнэлгээний дагуу	Уурхайн газар нутагт	-	Дотоод зардал		Байнга	Гамшгаас хамгаалах тухай хууль
Гал түймэр	Галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолоыг зохих газруудад байрлуулах	Уурхайн бүсэд	-	Дотоод зардал		Байнга	Галын аюулгүй байдлын тухай хууль
Хүн малын гоц халдварт өвчин	Гамшгаас хамгаалах эрсдэлийн үнэлгээний дагуу	Уурхайн газар нутагт	-	Дотоод зардал		Байнга	Гамшгаас хамгаалах тухай хууль
<b>Нийт</b>				<b>Дотоод зардал</b>			

## 11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн хог хаягдал	Ахуйн хог хаягдлыг орон нутгийн нийтийн аж ахуйн газартай гэрээ байгуулан, нийлүүлэх	Уурхайн бүх ахуйн хог хаягдал	рэйс	12	20,000	240,000	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль
	Хог хаягдлын цэг, бохирын цооногт ариутгал хийх	Хог хаягдлын цэг, бохирын цооног	удаа	4	Дотоод зардал		Улирал тутам	Хог хаягдлын тухай хууль
Технологийн хог хаягдал	Технологийн хог хаягдлыг хог боловсруулах мэргэжлийн байгууллагад нийлүүлэх	Уурхайн бүх технологийн хог хаягдал	удаа	4	Дотоод зардал		Улирал тутам	Хог хаягдлын тухай хууль
Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар зайлуулах, устгуулах	Уурхайн аюултай хог хаягдал	рэйс	1	320,000	320,000	Улирал тутам	Хог хаягдлын тухай хууль
	Аюултай хог хаягдыг ангилан, түр хадгалах цэгт хуулийн хүчинтэй хугацаанд зориулалтын саванд хадгалах	Уурхайн аюултай хог хаягдал	-	-	Дотоод зардал		Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
	<b>Нийт</b>				<b>570,000</b>			

## 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
<b>Агаар</b>							
<ul style="list-style-type: none"> <li>Тоосны агууламж (нийт, PM10, PM2.5)</li> <li>Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)</li> <li>Азотын исэл (NOx)</li> <li>Хүхэрлэг хий (SO<sub>2</sub>)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөрс хуулалт хийж буй талбай</li> <li>Хүдэр олборлолт хийж буй талбай</li> <li>Баяжуулах үйлдвэрийн орчин</li> </ul>	Улирал тутам	4	30,000	360,000	-	MNS 6063:2010 MNS 4585:2016
<ul style="list-style-type: none"> <li>Температур, шуугианы түвшин, доргион, гэрэлтүүлэг, чийгшил,</li> <li>Тоосжилт (нийт тоос, PM10, PM2.5)</li> <li>CO, SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>)</li> </ul>	Ажлын байр	Улирал тутам	4	20,000	80,000	-	MNS 4585:2016 MNS 5002-2000
<b>Хөрс</b>							
<ul style="list-style-type: none"> <li>Хөрсний үржил шимийн үзүүлэлт (pH, ялзмаг, карбонат, Ca<sup>2+</sup>, Mg<sup>2+</sup>, K<sub>2</sub>O, P<sub>2</sub>O<sub>5</sub>)</li> <li>Механик бүрэлдэхүүн</li> <li>Хүнд металлууд (Cr, Pb, Cd, Ni, Zn)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Овоолгын талбай</li> <li>Машин механизмын зогсоол</li> <li>Гаалийн агуулах</li> <li>Баяжуулах үйлдвэрийн талбай</li> <li>Уурхайн кемп</li> <li>ШТС</li> </ul>	Жилд 1 удаа	1	150,000	150,000	-	MNS 5850:2008 MNS 3310:91 MNS 3298:1990 MNS 3307:91 MNS ISO 10390 MNS 4006:1988 MNS 2143:2000



Усан орчин							
<ul style="list-style-type: none"> <li>Усны ерөнхий химийн шинжилгээ (pH, Ca<sup>2+</sup>, Mg<sup>2+</sup>, NH<sub>4</sub><sup>+</sup>, Na<sup>+</sup>, K<sup>+</sup>, Fe<sup>3+</sup>, SO<sub>4</sub><sup>2-</sup>, HCO<sub>3</sub><sup>-</sup>, Cl<sup>-</sup>, NO<sub>2</sub><sup>-</sup>, NO<sub>3</sub><sup>-</sup>)</li> <li>Бактереологийн шинжилгээ (нийт нянгийн тоо, гэдэсний бүлгийн нян, халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян, Escherichia Coli, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч /Salmonella, Shigella/, Сульфид задлагч агааргүйтэн /Clostridium Perfringens/)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Уурхайн худаг</li> <li>Кемпийн худаг</li> <li>Ус цэвэршүүлэгч</li> <li>Бохир ус</li> </ul>	Жилд 2 удаа	2	40,000	320,000	-	MNS 900:2005 MNS 6148:2010 MNS 4943:2015 MNS ISO 10523-2:2003 MNS ISO 4889-99 MNS ISO 6059:2005 MNS ISO 2572-99 MNS ISO 9297:2005 MNS 4425:97 MNS ISO 7890:2001 MNS 4431-2005 MNS 4428-97 MNS 4430:2005
<b>Нийт</b>					<b>910,000</b>		

### 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2023 он		
		Сар		
Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийлгэх	Дотоод төлөвлөлтөөр	1-12 сар	Байгаль орчны ахлах инженер, Байгаль орчны инженер	-
Байгаль орчныг хамгаалах болон аюулгүй ажиллагаатай холбогдсон сургалтыг жилд 1-2 удаа тогтмол хийж байх	Дотоод зардал	1-12 сар	Байгаль орчны ахлах инженер, Байгаль орчны инженер, ХАБ-н инженер	-
Байгаль орчныг хамгаалах жилийн тайлан, төлөвлөгөөг БОНХЯ болон орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь гаргаж өгч байх	Дотоод төлөвлөлтөөр	1-12 сар	Байгаль орчны ахлах инженер, Байгаль орчны инженер	-
Газар, ус ашигласны төлбөрийг тогтоосон хугацаанд барагдуулах	Дотоод зардал	1-12 сар	Байгаль орчны ахлах инженер, Байгаль орчны инженер	-
Болзошгүй аюул ослын үед орон нутгийн эмнэлгийн болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар тохиролцож гэрээ байгуулж ажиллах	Дотоод зардал	1-12 сар	Байгаль орчны ахлах инженер, Байгаль орчны инженер, ХАБ инженер	-
<b>Нийт</b>	<b>Дотоод зардал</b>			

**14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах ажилтан	Зохион байгуулах газар
Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгийн газар	Уурхайн байгаль хамгааллын ажлын талаар мэдээлэл өгөх	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлт, гүйцэтгэл	2023/11	Дотоод зардал	Байгаль орчны ахлах инженер, Байгаль орчны инженер	Сэлэнгэ аймаг
Нөлөөлөлд өртөгч оршин суугчид	Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар мэдээлэх		2023/04	Дотоод зардал	Байгаль орчны ахлах инженер, Байгаль орчны инженер	Сэлэнгэ аймаг, Хүдэр сум
БОАЖЯ-ны ХБОБНУ-ын газарт	Тайлан, төлөвлөгөө батлуулах		2023/11-2024/01	Дотоод зардал	Байгаль орчны ахлах инженер, Байгаль орчны инженер	Улаанбаатар хот
<b>Нийт</b>				Дотоод зардал		

**15. ТӨМӨРТЭЙ УУРХАЙН 2023 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН НИЙТ ЗАРДАЛ**

№	Арга хэмжээ	Зардал мян.төг
1	Сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,800.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	4,500.0
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	12,420.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	Дотоод зардал
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	570.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	910.0
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Дотоод зардал
10	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	Дотоод зардал
<b>Нийт</b>		<b>21,200.0</b>